



ОЛОН УЛСАД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

NEWSLETTER


“Мандах- 2019” Олон улсын эрдэм шинжилгээний хурал амжилттай зохион байгуулагдлаа.

Мандах Их Сургууль эрдэмтэн багш, мэргэжлийн байгууллагын судлаач болон оюутнуудыг хамруулсан эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулдаг уламжлалыг бий болгосон. Үүний нэг нь олон улсын эрдэм шинжилгээний хурал юм. Бид энэхүү олон улсын хурлыг 2012 оноос эхлэн 2 жил тутам тогтмол зохион байгуулж байна.

Дөрөв дэхь удаагийн Олон улсын эрдэм шинжилгээний МАНДАХ-2019 хурлыг Корпорэйт зочид буудлын Улаанбаатар их танхимд 2019 оны 5-р сарын 24-нд амжилттай зохион байгууллаа.

Эрдэм шинжилгээний “Мандах эрдэм” сэтгүүлийн анхны дугаар хэвлэгдэн гарлаа.

“Мандах эрдэм” сэтгүүлийн анхны дугаарт эдийн засаг, хүмүүнлэг, боловсрол, инженер, мэдээлэл технологийн чиглэлээр бичигдсэн 11 өгүүлэл англи, монгол хэл дээр нийтлэгдсэн байна.



Эрдэм шинжилгээ, судалгаа

“Мандах их сургуулийн багш нарын эрдэм шинжилгээний хурал-2019”

Мандах их сургуулийн багш нарын эрдэм шинжилгээний хурал 2019 оны 2-р сарын 28-ны өдөр амжилттай болж өндөрлөлөө. Энэхүү эрдэм шинжилгээний хурал нь багш нар харилцан мэдлэг туршлага солилцох, судалгааны багуудын үйл ажиллагаа болон хамтарсан судалгаа шинжилгээний ажлыг дэмжих зорилготой байв. Энэ удаагийн эрдэм шинжилгээний хурлаар 4-н судалгааны багаас шалгарсан 10 илтгэлийг хэлэлцүүлээ. Мандах их сургуулийн багш нарын эрдэм шинжилгээний хуралд илтгэлээ хэлэлцүүлсэн судалгааны баг, багш нарыг тодотговол:

I. Эдийн засаг, бизнесийн судалгааны баг

Сэдэв: “Төв аймгийн эдийн засгийн төрөлжилт”

Илтгэгч: Л. Дансранбавуу /багш/, Ж. Гантулга /багш/

Сэдэв: “Улсын төсөв дэхь татварын төвлөрөл”

Илтгэгч: С. Цолмон /доктор, дэд профессор/, Г. Уянга /багш/

Сэдэв: “Хэрэглэгчийн үнэ цэнд үндэслэн орон сууцны үнийг оновчтой тодорхойлох нь”

Илтгэгч: С. Цолмон /доктор, дэд профессор/, Б.Сайнжаргал /багш/

II. Бүртгэл, санхүүгийн судалгааны баг

Сэдэв: “50% - иас дээш хувьцаа эзэмшигч болон хөрөнгийн өгөөжийн хамаарлын судалгаа”

Илтгэгч: А. Наранцэцэг /доктор/, Ц. Одгараг /багш/

Сэдэв: “Дулааны цахилгаан станцын өртөг тооцох арга зүйг боловсронгуй болгох нь /ДЦС-4 ТӨХК-ИЙН жишээн дээр/”

Илтгэгч: Х. Нямбаяр /дэд профессор/, Б. Бадрал /ахлах багш/, Ц. Номин /багш/

Сэдэв: “Цахим төлбөрийн баримтын хэрэгжилт ААН байгууллагын орлогод нөлөөлсөн байдал”

Илтгэгч: М. Энхсүрэн /ахлах багш/, Б. Баатарцогт /багш/

III. Хүмүүнлэг, боловсрол судлалын судалгааны баг

Сэдэв: “Оюутны бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх зарим асуудалд”

Илтгэгч: Т. Сумъяа /дэд профессор/, Э. Оюун-Эрдэнэ /ахлах багш/

Сэдэв: “Оюутан өөрийн дотоод ур чадварыг үнэлэх байдалд хийсэн судалгаа”

Илтгэгч: Ж. Төгсөө /ахлах багш/

Сэдэв: “Хөнгөн уншлагын аргыг X reading.com цахим номын санг ашиглан хэрэгжүүлсэн байдал”

Илтгэгч: Ш. Нандинцэцэг /багш/, Н. Ариунаа /багш/

IV. Суурь шинжлэх ухаан, инженерчлэлийн судалгааны баг

Сэдэв: “Математикийн хичээлийн дүнг оюуны хөгжлийн түвшинтэй харьцуулсан судалгаа”

Илтгэгч: Н. Далайсайхан /ахлах багш/, С. Анхбаяр /багш/



Эрдэм шинжилгээ, судалгаа

“Оюутны эрдэм шинжилгээний хурал-2019”

Мандах их сургуулийн оюутны эрдэм шинжилгээний хурал 2019 оны 2 - р сарын 27-нд амжилттай зохион байгуулагдлаа. Оюутны эрдэм шинжилгээний хуралд судалгааны баг бүрээс шалгаран ирсэн **10** илтгэл хэлэлцүүлснээс:

Тэргүүн байранд

“Татварын орлого болон эдийн засгийн зарим үзүүлэлтүүдийн урт хугацааны хамаарал”

Илтгэгч: Г. Мөнхтүвшин, С. Цэвээнжаргал /НББ-Аудит III/

Удирдагч багш: С. Цолмон /Доктор (Ph.D), дэд профессор/

Дэд байранд

“Хөрөнгө оруулагчдын зан төлөвийн хүчин зүйлээр хувьцааны ханшийг таамаглах нь”

Илтгэгч: А. Наранхуяг /НББ-Аудит III/

Удирдагч багш: С. Цолмон /Доктор (Ph.D), дэд профессор/

Гутгаар байранд

“Монголын хөрөнгийн бирж болон Америкийн хөрөнгийн бирж дээрх хувьцааны техник шинжилгээ болон ханшийн таамаглал”

Илтгэгч: А. Энхтөр, А. Должинсүрэн /НББ-Татвар III/

Удирдагч багш: С. Цолмон /Доктор (Ph.D), дэд профессор/

Тусгай байранд

“Ажлын капиталын удирдлага ба компанийн ашиг хоорондын хамаарал”

Илтгэгч: Ж. Нарангэрэл /НББ-Аудит IV/

Удирдагч багш: А.Наранцэцэг /Доктор (Ph.D)/

“DuPont аргыг ашиглан ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг компаниудын санхүүгийн байдлыг үнэлэн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах нь”

Илтгэгч: Д. Халиунаа /НББ-Аудит IV/

Удирдагч багш: А. Наранцэцэг /Доктор (Ph.D)/ тус тус эзэллээ.



Эрдэм шинжилгээ, судалгаа

“Мандах- 2019” Олон улсын эрдэм шинжилгээний хурал

Мандах Их Сургууль эрдэмтэн багш, мэргэжлийн байгууллагын судлаач болон оюутнуудыг хамруулсан эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулдаг уламжлалыг бий болгосон. Үүний нэг нь олон улсын эрдэм шинжилгээний хурал юм. Бид энэхүү олон улсын хурлыг 2012 оноос эхлэн 2 жил тутам тогтмол зохион байгуулж байна.

Дөрөв дэхь удаагийн Олон улсын эрдэм шинжилгээний МАНДАХ-2019 хурлыг Корпорэйт зочид буудлын Улаанбаатар их танхимд 2019 оны 5-р сарын 24-нд амжилттай зохион байгууллаа.

Тус хуралд ОХУ-ын Буриадын их сургууль, АНУ-ын Мичиганы их сургууль болон Auburn-ийн их сургууль, Хорват улсын Загребийн их сургууль болон North University, БНСУ-ын Handong Global University, Унгар улсын Debrecen University болон Сангийн яам, Үндэсний статистикийн хороо, Татварын ерөнхий газар болон МУИС, МУБИС, СЭЗИС, ХУИС зэрэг дотоодын томоохон их сургуулиуд, төрийн ба төрийн бус байгууллагын эрдэмтэн багш, судлаач нар оролцлоо.

Энэ удаагийн хурал тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд бизнесийн удирдлага, боловсрол, хүмүүнлэг, мэдээллийн технологийн чиглэлийн тулгамдсан асуудлуудыг хөндсөн 20 гаруй сонирхолтой илтгэлүүд тавигдаж, оролцогчид идэвхитэй оролцож, олон сонирхолтой асуултуудыг илтгэгч нараас асууж тодруулж байлаа.

Уг хурлыг зохион байгуулснаар гадаад, дотоодын эрдэмтэн судлаач нар харилцан туршлага солилцох, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, тухайн улс орны судалгааны ажлын чиг хандлагын талаар харилцан мэдээлэл солилцох, мэдлэгээ хуваалцах чухал ач холбогдолтой боллоо.



Дотоод хамтын ажиллагаа

Хамтран ажиллах тухай санамж бичигт гарын үсэг зурлаа

Мандах Их Сургууль, Ай И Ди Си байгууллагатай хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичгийг 2019 оны 2-р сарын 28-ны өдөр байгуулав. Уг санамж бичигт Мандах Их Сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал, Доктор Ph.D, дэд профессор Ч. Төрбадрах, Ай И Ди Си байгууллагын захирал М. Найдалмаа нар гарын үсэг зурснаар хамтын ажиллагаагаа эхлүүллээ. Санамж бичгийн хүрээнд Мандах их сургуулийн англи хэлний багш нарын чадавхийг дээшлүүлэх болон багш, оюутнуудад зориулсан TEFL/TESOL хөтөлбөр, Грийнвичийн Их сургуулийн (ИБУИНВУ) итгэмжилсэн Мэргэжлийн Англи хэлний олон улсын хөтөлбөр болон бизнесийн удирдлага, маркетинг, олон нийтийн харилцааны чиглэлээр мэргэшүүлэх хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж, баталгаажуулна. Ингэснээр Мандах Их сургуулийн багш, оюутнууд мэргэжлийн ур чадвар, гадаад хэлний мэдлэгээ өндөр түвшинд сайжруулах боломжтой болох юм.

Мандах Их Сургууль болон "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, ШУТИС-ийн харьяа Ш.Отгонбилэгийн нэрэмжит Технологийн сургуулийн хооронд хамтран ажиллах санамж бичиг байгуулж 2019 оны 04 сарын 03-ны өдөр Мандах Их Сургуулийн сургалт эрхэлсэн дэд захирал Доктор (Ph.D), дэд Профессор Ч.Төрбадрах, Технологийн сургуулийн захирал, Доктор (Ph.D) Д.Зоригтхүү нар гарын үсэг зурлаа. Санамж бичгийн хүрээнд чанарын менежментийн тогтолцоо, сургалтын дэвшилтэт арга технологи нэвтрүүлж, хэрэгжүүлэхэд харилцан туршлага солилцох, хамтарсан хурал, сургалт, семинар зохион байгуулах зэрэг хэд хэдэн чиглэлд хамтран ажиллахаар төлөвлөөд байна.

Хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах арга хэмжээний үеэр Мандах Их Сургуулийн НББТэнхимийн багш Ц.Одгарав "Санхүүгийн бүртгэл, Удирдлагын бүртгэл" сэдвээр, Технологийн сургуулийн Сургалтын албаны дарга Д.Болор-Эрдэнэ "Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулсан тухай" танилцуулга хийж, харилцан туршлага солилцлоо. Тус арга хэмжээнд Мандах Их Сургуулийн Захирлын ажлын албаны дарга дэд Профессор С.Энхтуяа, Хөтөлбөр хариуцсан ажилтан Б.Мөнхбат болон Технологийн сургуулийн сургалт хариуцсан орлогч захирал Н.Манчук, Эрдэм шинжилгээ, судалгаа хариуцсан орлогч захирал Ц.Төгсбуян болон албаны бусад хүмүүс оролцлоо.




Дотоод хамтын ажиллагаа

Мандах их сургууль болон Голомт банкны хооронд хамтран ажиллах тухай гэрээ байгуулав

Мандах их сургууль, Голомт банкны хооронд хамтран ажиллах тухай гэрээнд гарын үсэг зурах ёслолын ажиллагаа 2019 оны 5-р сарын 29-ний өдөр Мандах их сургуулийн хурлын танхимд болов. Ёслолын ажиллагаанд Мандах их сургуулийн захирал, профессор Г. Нанжид тэргүүтэй Мандах их сургуулийн удирдлага, тэнхимийн багш нарын төлөөлөл, Голомт банкны үйл ажиллагаа хариуцсан захирал Д. Сугар, хүний нөөцийн хэлтсийн захирал Г. Уянга нар оролцлоо. Гэрээнд Мандах их сургуулийг төлөөлөн сургалт эрхэлсэн дэд захирал доктор, дэд профессор Ч. Төрбадрах, Голомт банкныг төлөөлөн үйл ажиллагаа хариуцсан захирал Д. Сугар нар гарын үсэг зурав.

Ёслолын ажиллагааны үеэр хоёр тал гэрээнд тусгагдсан болон цаашид хамтран ажиллах чиглэлийн талаар харилцан санал солилцов. Хамтран ажиллах гэрээний хүрээнд оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг сайжруулах, оюутныг хөгжүүлэх клубын үйл ажиллагааг дэмжих, оюутны дадлага хийх таатай нөхцлийг бүрдүүлэх, ажлын байранд бэлтгэх чиглэлээр хамтран ажиллахаар талууд тохиролцлоо.

Голомт банк 2300 гаруй ажилтан албан хаагчидтай бөгөөд үүнээс 120 гаруй нь Мандах их сургуулийн төгсөгчид байдаг юм байна.



Гадаад хамтын ажиллагаа

Мандах их сургуулийн захирал, профессор Г. Нанжид АНУ-ын Пэрэгрин Академик Сервис, Манлайллын Академийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа

2019 оны 4-р сарын 29-нд АНУ-ын Пэрэгрин Академик Сервис, Манлайллын Академийн ерөнхийлөгч Олин Оедековен тэргүүтэй төлөөлөгчид Мандах Их Сургуульд зочлов. Мандах Их Сургуулийн Захирал, Профессор Г.Нанжид төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа.

Уулзалтанд АНУ-ын Пэрэгрин Академийн дэд ерөнхийлөгч Лаурел Викланд, Олон улсын Хөтөлбөр, Маркетинг хариуцсан захирал Алимаа, Хэрэглэгчийн Үйлчилгээний дэд захирал Кэйла Вос, Мандах Их Сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал Ч. Төрбадрах, Санхүү, хөгжлийн бодлого эрхэлсэн дэд захирал С. Энхтүвшин нар оролцов.

Уулзалтын эхэнд Мандах Их Сургуулийн захирал Г. Нанжид сүүлийн жилүүдэд Мандах Их Сургууль дээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, ололт амжилт, ахиц дэвшлийн талаар төлөөлөгчдөд дэлгэрэнгүй танилцууллаа. Түүнчлэн хоёр тал хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар харилцан санал солилцов.

Төлөөлөгчид Мандах Их Сургуулийн хичээлийн шинэ байртай танилцаж, орчин үеийн техник хэрэгслээр бүрэн тоноглогдсон анги танхим, номын сан, спортын заал, цайны газрыг үзэж сонирхоод, багш, оюутнуудын ажиллах болон суралцах таатай орчин бүрдсэн байгааг хараад сэтгэл хангалуун байгаагаа илэрхийллээ.

Мандах Их Сургууль АНУ-ын Пэрэгрин Академитай 2012 оноос хойш хамтран ажиллаж байгаа бөгөөд бизнесийн хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудын суралцах гарцыг жил бүр үнэлүүлдэг. Мэргэжлийн суурь ба мэргэшүүлэх 12 төрлийн хичээлийн агууллагаар өгсөн шалгалтын дүнгээр Мандах Их Сургууль ACBSP-ийн 8-р бүсийн сургуулиуд болон Монголын бусад их дээд сургуулийн дундаж үзүүлэлтээс дээгүүр үнэлэгдэж ирсэн байна.



Гадаад хамтын ажиллагаа

Гадаадын их сургуулийн төлөөлөгчидтэй уулзаж, хамтын ажиллагааны чиглэлээр харилцан санал солилцлоо

“Мандах-2019” Олон улсын эрдэм шинжилгээний 4 дэх удаагийн хурлын үеэр гадаадын төлөөлөгчидтэй уулзалтууд зохион байгуулав. Үүнд Мандах Их Сургуулийн захирал, профессор Г. Нанжид тус хуралд оролцож, илтгэл тавьсан ОХУ-ын Буриадын Улсын Их Сургуулийн Гадаад хэлний тэнхмийн доктор, профессор Любовь Раднаева, Хорват улсын Загребын Их сургуулийн Эдийн засаг, бизнесийн факультетын Маркетингийн тэнхмийн эрхлэгч доктор, профессор Тихомир Вранесевик, доктор профессор Томислав Гело, БНСУ-ын Хангдонг Глобал Их Сургуулийн захирлын бие төлөөлөгч доктор, дэд профессор Юн Сён Ким нарыг хүлээн авч уулзаж,

- Багш, оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх
- Эрдэм шинжилгээний сэтгүүл, ном товхимолыг харилцан солилцох
- Эрдэмтэн багш нарыг харилцан урьж ажиллуулах
- Хос диплом олгох хөтөлбөр хэрэгжүүлэх
- Хамтарсан эрдэм шинжилгээ, судалгааны хурал, семинарыг зохион байгуулж байх талаар харилцан санал солилцов.

Уулзалтаас гарсан саналуудыг тусган сургууль хооронд хамтран ажиллах Санамж бичиг, гэрээ хэлэлцээр байгуулахаар тохиролцлоо.



Магадлан итгэмжлэл

Ази,Номхон далайн орнуудын чанарын сүлжээ байгууллагын төлөөлөгчид тус сургууль дээр ажиллаа.

Ази,Номхон далайн орнуудын чанарын сүлжээ байгууллагаас Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд чанарын баталгаажуулалт хийх ажлын хүрээнд тус байгууллагаас газар дээр нь ирж шалгах комиссын гишүүд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн харилцагч байгууллагын талуудтай уулзаж, үйл ажиллагаатай нь танилцахаар Номхон далайн орнуудын чанарын сүлжээний дэд ерөнхийлөгч Анжела Юнг-Чи Хоү, Ази,Номхон далайн орнуудын чанарын бүртгэлийн дарга Жаганнат Патил, АНУ-ын Бизнесийн сургууль, хөтөлбөрийн магадлан итгэмжлэх зөвлөлийн дэд захирал Диана Халлеруд зэрэг бүрэлдэхүүнтэй мэргэжлийн шинжээчид болон Магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Ажлын албаны захирал Ж. Ариунболд тэргүүтэй мэргэжилтнүүд 2019 оны 6-р сарын 4-ний өдөр Мандах их сургууль дээр ажиллалаа.

Мандах их сургуулийн захирал, профессор Г. Нанжид сургуулийнхаа үйл ажиллагаа болон сургалт, эрдэм шинжилгээ судалгааны талаар дэлгэрэнгүй танилцуулсны дараа Мандах их сургуулийн видео танилцуулгыг комиссын гишүүдэд үзүүлэв. Мөн энэ үеэр Мандах их сургууль дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоо болон чанарын удирдлагын ISO9001:2015 стандартыг хэрхэн нэвтрүүлж, хэрэгжүүлж байгаа талаар танилцуулав. Шинжээчдийн зүгээс Мандах их сургууль болон Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл хоорондын ажлын уялдаа холбоо, магадлан итгэмжлүүлэхийн ач холбогдол, ахиц дэвшил, санхүүгийн тогтвортой байдлыг хэрхэн хангаж ажилладаг талаар асууж лавлан тодорхой хариултыг авлаа.

Хяналтын комиссын гишүүд болон Магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Ажлын албаны гишүүд Мандах их сургуулийн шинэ цогцолбор барилгатай танилцаж, орчин үеийн техник хэрэгслээр бүрэн тоноглогдсон анги танхим, номын сан, спортын заал, цайны газрыг үзэж сонирхоод, багш, оюутнуудын ажиллах болон суралцах таатай орчин бүрдсэн байгааг хараад сэтгэл хангалуун байгаагаа илэрхийллээ.



Үйл явдлууд

Ерөнхий боловсролын сурагчдад зориулж, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгууллаа.

Мандах их сургуулийн нээлттэй хаалганы өдөрлөг 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа.

Өдөрлөгийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын 16 сургуулийн сурагчид хүрэлцэн ирж, сургуулийн үйл ажиллагаа, орчинтой танилцаж, сургалтын хөтөлбөр, дугуйлан клуб, оюутны хөгжлийн зээл, тэтгэлэгт хөтөлбөрийн талаар мэдээлэл авлаа.

Өдөрлөгт хүрэлцэн ирсэн сурагчдад тус сургуулийн Эдийн засаг, бизнесийн тэнхмийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор С.Цолмон “Математикийн шалгалтыг амжилттай өгөх зөвлөмж”, Гадаад хэлний тэнхмийн ахлах багш Ж.Төгсөө, багш Т.Оюун-Эрдэнэ нар “Хэл сурахын давуу тал ба түгээмэл гаргадаг алдаанууд” сэдвээр сонирхолтой лекц уншлаа.

Түүнчлэн Мандах их сургуулийн авъяаслаг оюутнууд урлагийн тоглолт үзүүлж, оюутны зөвлөлөөс асуулт, хариултын тэмцээнийг зохион байгуулж, амжилттай оролцсон сурагчдад гарын бэлэг гардууллаа.



“Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 олон улсын чанарын стандартыг Мандах Их сургуульд нэвтрүүлсэн туршлагаа хуваалцах уулзалт”-ыг зохион байгууллаа.

Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 олон улсын стандартыг Мандах Их Сургуульд нэвтрүүлсэн туршлагаа хуваалцах уулзалтыг Мандах Их Сургууль санаачлан, Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөлийн /БМИҮЗ/ дэмжлэгтэйгээр 2019 оны 5 дугаар сарын 3-ны өдөр зохион байгууллаа. Тус уулзалтанд 28 их дээд сургуулийн чанарын баталгаажуулалт болон хяналт шинжилгээ-үнэлгээ хариуцсан 40 гаруй мэргэжилтнүүд оролцож, чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 олон улсын стандартын талаарх ойлголт, мэдлэгийг олж авсны зэрэгцээ олон улсын стандартыг нэвтрүүлэхэд шаардагдах бэлтгэл ажил, хэрэгжүүлэх үйл явц, ач холбогдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авлаа.

Уулзалтыг нээж, Мандах Их Сургуулийн захирал, профессор Г. Нанжид хэлсэн үгэндээ “ISO стандартыг нэвтрүүлснээр тухайн байгууллагын бүхий л үйл ажиллагааг уялдаа холбоонд нь төлөвлөх, удирдах, хянах, сайжруулах, үйл явцыг тогмолжуулах, чанаржуулахад өндөр ач холбогдолтой бөгөөд тухайн хамт олон байгууллагынхаа хөгжил, дэвшлийн төлөө нэгэн зорилгын дор нэгдэн ажиллахад хөшүүрэг болдгоороо чухал ач холбогдолтой. Мөн энэхүү стандартыг нэвтрүүлснээр үндэсний болон олон улсын магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагыг ханган биелүүлэхэд ихээхэн дөхөм болдог давуу талтай” гэдгийг онцлон тэмдэглээд “Дээд боловсролын байгууллагуудын үндсэн зорилго бол монголын ирээдүй болсон залуучуудыг өндөр боловсролтой боловсон хүчин болгон бэлтгэх явдал юм. Тиймээс өнөөдөр нэгэн зорилготой ажилладаг та бүхэнтэй олон улсын стандартыг сургууль дээрээ нэвтрүүлсэн туршлагаасаа хуваалцаж, санал бодлоо солилцож байгаа юм” гэлээ.



Санаачлагч,
Зохион байгуулагч



МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

Дэмжигч
байгууллага



Б.М.И.Ү.
ЗӨВЛӨЛ
БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

**МАНДАХ ИХ СУРГУУЛЬД
ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ
ISO 9001:2015 ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ
НЭВТРҮҮЛСЭН ТУРШЛАГАА ХУВААЛЦАХ
УУЛЗАЛТ**

Оролцогч сургуулиуд:



Уралдаан тэмцээн

“Bloomberg B-School Connection Educational Resource Centre”-ийн бичил кейс судалгаанд суурилсан хоёр дахь удаагийн тэмцээнд Мандахчууд амжилттай оролцлоо.

Перегрин Академик Сервис, Манлайллын “Шонхор” академи хамтран “Bloomberg B-School Connection Educational Resource Center”-ийн бичил кейс судалгаанд суурилсан уралдаант тэмцээнийг B-School Connection олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч сургуулиудын хооронд хоёр дахь удаагаа 2019 оны 5 дугаар сарын 2-ны өдөр болсон.

Энэ удаагийн тэмцээн монгол, англи хоёр хэл дээр тусдаа шүүлттэй зохион байгуулагдсанаараа онцлогтой бөгөөд тэмцээнд нийт 15 их, дээд сургуулиудаас тус бүр 4 оюутан, 1 зөвлөх багштай 22 баг оролцон өрсөлдлөө.

Тэмцээнд оролцсон багууд:

Монгол хэл дээр илтгэсэн багууд:

- ◆ МУИС- Бизнесийн сургуулийн “E-30 Coupe” баг
- ◆ Санхүү, Эдийн засгийн их сургуулийн “Peak” баг
- ◆ ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн “Nomads” баг
- ◆ Мандах Их Сургуулийн “Судлаач Оюутан 1” баг
- ◆ Олон улсын эдийн засаг үндэсний дээд сургуулийн “Тэмүүлэл” баг
- ◆ ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн “Competence” баг
- ◆ Сан их сургуулийн “Green Zone” баг
- ◆ Сэрүүлэг их сургуулийн “Shake Up” баг
- ◆ Идэр их сургуулийн
- ◆ МУИС-ийн Бизнесийн сургуулийн “Imperium” баг
- ◆ Эдийн засаг үндэсний дээд сургуулийн “Falcons” баг
- ◆ 12, ХУИС-ийн Бизнесийн сургуулийн “Шонхорууд” баг

Англи хэл дээр илтгэсэн багууд:

- ◆ МУИС- Бизнесийн сургуулийн “Cosmos” баг
- ◆ ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн “Leadfull” баг
- ◆ Мандах Их Сургуулийн “Судлаач Оюутан 2” баг
- ◆ Олон улсын эдийн засаг үндэсний дээд сургуулийн “Future” баг
- ◆ ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн “Researcher” баг
- ◆ Сан их сургуулийн “Innovation” баг
- ◆ ХУИС-ийн Бизнесийн сургуулийн “Ravenclaw” баг
- ◆ ХУИС-ийн Хэл, соёлын сургуулийн “Four minds- One team” баг
- ◆ Эм Ай Ю дээд сургуулийн (MIU) “A-Team” баг
- ◆ 10, Летү Монгол их сургуулийн “Yellow Jackets” баг



Үүнээс монгол хэл дээрх илтгэлүүдээс Санхүү, эдийн засгийн их сургуулийн “Peak” баг 84 оноогоор 1-р байр, Мандах Их Сургуулийн “Судлаач оюутан 1” баг 75.3 оноогоор хоёрдугаар байр, Сан их сургуулийн “Green Zone” баг 73.3 оноогоор гуравдугаар байр тус тус эзэллээ.

Англи хэл дээр илтгэлүүдээс Сан их сургуулийн “Innovation” баг 92 оноогоор 1-р байр, Мандах Их Сургуулийн “Судлаач оюутан 2” баг 89.3 оноогоор хоёрдугаар байр, МУИС Бизнесийн сургуулийн “Cosmos” баг 80 оноогоор гуравдугаар байр тус тус эзэллээ.

Тэмцээний тэргүүн байранд шалгарсан багуудыг батламж, 500 доллар, дэд байрын багуудыг батламж, 300 доллар, гуравдугаар багуудыг батламж, 200 доллараар тус тус шагнагдлаа.

Уралдаан тэмцээн

Мандах их сургууль дээр математик, англи хэлний олимпиад зохион байгуулагдлаа.

Мандах их сургуулийн нэрэмжит Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдын дунд зохион байгуулсан Математик, Англи хэлний олимпиад 2019 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр амжилттай болж өндөрлөлөө. Тус олимпиадад Улаанбаатар хот болон орон нутгийн нийт 39 сургуулийн сурагчид оролцож өөрсдийн мэдлэг, чадвараа сорьлоо.

Математикийн олимпиадын шилдгүүд

Тэргүүн байранд Нийслэлийн Номуун сургуулийн сурагч Баасандорж овогтой Энхжин шалгарч 1-р дамжаанд 30 хувь хөнгөлөлттэй суралцах эрхийн бичиг болон үнэ бүхий зүйлээр,

Дэд байранд Нийслэлийн Ирээдүй цогцолбор II ахлах сургуулийн сурагч Нямбаяр овогтой Уянга болон Нийслэлийн Номуун сургуулийн сурагч Амарзаяа овогтой Жаргалсайхан нар шалгарч 1-р дамжаанд 20 хувь хөнгөлөлттэй суралцах эрхийн бичиг болон үнэ бүхий зүйлээр,

Гутгаар байранд Нийслэлийн 96-р сургуулийн сурагч Лхагвасүрэн овогтой Номин, Нийслэлийн Сант сургуулийн сурагч Нэргүй овогтой Гэгээнхүслэн нар шалгарч 1-р дамжаанд 10 хувь хөнгөлөлттэй суралцах эрхийн бичиг болон үнэ бүхий зүйлээр тус тус шагнагдлаа.

Англи хэлний олимпиадын шилдгүүд

Тэргүүн байранд Нийслэлийн 21-р сургуулийн сурагч Ганхуяг овогтой Тэлмүүн шалгарч 1-р дамжаанд 30 хувь хөнгөлөлттэй суралцах эрхийн бичиг болон үнэ бүхий зүйлээр,

Дэд байранд Нийслэлийн 84-р сургуулийн сурагч Гандэлэг овогтой Одбаяр, Өвөрхангай аймгийн Мэргэд цогцолбор сургуулийн сурагч Ганболд овогтой Бодьхүү нар шалгарч 1-р дамжаанд 20 хувь хөнгөлөлттэй суралцах эрхийн бичиг болон үнэ бүхий зүйлээр,

Гутгаар байранд Нийслэлийн 24-р сургуулийн сурагч Отгонжаргал овогтой Ану, Нийслэлийн Ирээдүй цогцолбор II Ахлах сургуулийн сурагч Мөнхбаяр овогтой Нинжин нар шалгарч 1-р дамжаанд 10 хувь хөнгөлөлттэй суралцах эрхийн бичиг болон үнэ бүхий зүйлээр тус тус шагнагдлаа.



Уралдаан тэмцээн

Статистикийн улсын олимпиадад амжилттай оролцлоо.

Мандах Их Сургуулийг Үүсгэн байгуулагч Б.Сандагсүрэнгийн нэрэмжит Статистикийн улсын III олимпиад 2019 оны 4-р сарын 14-ний өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Олимпиадын дэмжигч байгууллагаар Үндэсний Статистикийн Хороо хамтран ажиллаж, Мандах ИС, МУИС, СЭЗИС, ШУТИС-БУХС, ХААИС-ЭЗБС, ХУИС, ИЗОУИС, ОУЭЗБДС, МҮИС, ЭЗҮДС зэрэг 10-и, дээд сургуулийн 95 оюутан оролцож мэдлэг, чадвараа сорилоо.

Олимпиадын үйл ажиллагаанд Мандах Их Сургуулийн захирал, профессор Г.Нанжид, ҮСХ-ны дарга А.Ариунзаяа, ҮСХ-ны Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газрын дарга Доктор (Ph.D) А.Дэмбэрэл, Монгол улсын гавъяат багш Доктор(Ph.D), Профессор Г.Элдэв-Очир, Мандах Их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал Доктор (Ph.D), дэд профессор Ч.Төрбадрах, Мандах Их Сургуулийн Санхүү, хөгжлийн бодлого эрхэлсэн дэд захирал С.Энхтүвшин, оролцогч сургуулиудын эрдэмтэн багш нар оролцлоо.

Олимпиадын тестийг мэргэжлийн багш нар хамтран боловсруулж бэлтгэсэн нь харилцан туршлага солилцож, статистикийн мэргэжлийн нэр томъёо, сургалтын агуулга, чанарыг сайжруулах, энэ чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх үйл явцын үр дүнг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулсан чухал үйл ажиллагаа боллоо.



Мандах их сургуулийн “Мазаалай” баг Оюутны лигийн аваргаар тодорлоо

Монгол улсын их дээд сургууль, коллежийн оюутнуудын дунд зохион байгуулагдсан сагсан бөмбөгийн “Оюутны лиг 2018-2019” тэмцээн амжилттай болж өндөрлөлөө. Тус тэмцээнд 12 их, дээд сургуулийн баг тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорьж 4 сарын турш үргэлжлэн явагдаж 2019 оны 4-р сарын 4-ний өдөр дүнгээ гаргалаа.

Мандах Их Сургуулийн “Мазаалай” баг хэсгээсээ 3-р байраар шалгарч Этүгэн Их Сургуулийн-II шигшээ багтай тоглож 2:1 харьцаагаар хожиж дараагийн шатанд Мон Алтиус БТДСургуулийн шигшээ багтай тоглож хожил авснаар аваргын төлөө Цахим дээд сургуулийн шигшээ багтай тоглох эрхтэй болсон. Оюутны лигийн аваргын төлөөх тоглолт Спортын төв ордонд 2019 оны 4-р сарын 4-ны өдөр болж Мандах Их Сургуулийн баг Оюутны лигийн 2-р дивизионы аварга багаар шалгарч, НББАХ-4 дамжааны оюутан Т. Санчир "MVP" шагналын эзэн боллоо.



Уралдаан тэмцээн

Нягтлан бодох бүртгэлийн улсын Олимпиадад тэргүүн байр эзэллээ.

Мандах Их Сургуулийн санаачлагаар 1998 оноос нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудын дунд Нягтлан бодох бүртгэлийн улсын олимпиадыг жил бүр уламжлал болгон зохион байгуулагдаж ирсэн. Энэхүү олимпиад нь тус салбарыг сонгон суралцаж буй оюутнуудын мэдлэг чадварыг хөгжүүлэх, ирээдүйн судлаач, манлайлагчдыг бэлтгэх, багш нарын мэдлэг, туршлагыг харилцан солилцох, нягтлан бодох бүртгэлийн салбарт үнэтэй хувь нэмэр оруулсан ахмадуудаа алдаршуулах зорилготой.

Нягтлан бодох бүртгэлийн улсын олимпиадын үе үеийн оролцогчдоос бодлого тодорхойлох мэргэжлийн байгууллагын удирдлагууд, үндэстэн дамнасан корпорациудын бизнесийн зөвлөх, санхүү эрхэлсэн захирал, аудит, үнэлгээний компанийн захирлууд, мөн 30 гаруй их дээд сургуулийн багш нар төрж гарчээ.

Энэ удаагийн Нягтлан бодох бүртгэлийн улсын XXII олимпиад 4 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд болж, МУИС, Мандах Их Сургууль, ХААИС, Отгонтэнгэр ИС, СЭЗИС, Сан ИС, Улаанбаатар эрдэм ИС, ОУЭЗБДС, ХУИС, Этүгэн ИС, МУИС-ийн Эрдэнэт сургууль, Мандах ИС-ийн Дархан салбар гэсэн 12 их дээд сургуулийн 60 оюутан төгсгөлийн шатанд эрдэм мэдлэгээ сорин өрсөлдлөө.

XXII олимпиадад багийн дүнгээр Мандах Их Сургууль 1-р байр, Олимпиадын аварга оюутнаар Мандах Их Сургуулийн НББ-Банкны 3-р дамжааны оюутан О.Сарангуа, 2-р байранд НББ-Аудит 3-р дамжааны оюутан Б.Нямтуяа, шагналт 5-р байранд НББ-Аудит 3-р дамжааны оюутан Г.Мөнхтүвшин, Багаа амжилттай удирдаж тэргүүн байр эзэлсэн шилдэг багшаар Мандах Их Сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш Г.Золбоо нар тодорлоо. Мөн Мандах Их Сургуулийн Дархан салбар сургуулийн оюутан А.Шижирбаатар, Б.Анхзаяа нар “Тор-10”-ын 5, 7-р байранд шалгарч багийн дүнгээрээ 5-р байр эзэллээ.



Ж. Питр Морроугийн нэрэмжит ХААН банкнаас уламжлал болгон зохион байгуулдаг олимпиадад Мандахчууд амжилттай оролцлоо

Банк санхүүгийн чиглэлээр суралцаж буй оюутнуудын бүтээлч сэтгэлгээ, онолын болон мэргэжлийн мэдлэг, ур чадварыг нээн илрүүлэх зорилгоор уламжлал болгон зохиогддог Ж.Питер Морроугийн нэрэмжит “ХААН Банкны олимпиад” энэ жил найм дахь жилдээ амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Энэ удаагийн олимпиад 4 дүгээр сарын 20-23-ны өдрүүдэд болж, МУИС, СЭЗИС, Мандах Их сургууль, ИЗОУИС, ОУЭЗБДС, МУИС, Улаанбаатар Эрдэм Их сургууль гэсэн 7 их дээд сургуулийн 70 оюутан мэдлэг, чадвараа сорьж өрсөлдлөө. Тус олимпиадад Мандах Их сургууль 4 дэх жилдээ амжилттай оролцож байгаа бөгөөд сургуулийг төлөөлж НББ-Банк, Санхүү банк хөтөлбөрийн 3,4-р дамжааны оюутнууд багийн болон ганцаарчилсан төрөлд өрсөлдсөн юм. Олимпиад эрсдэлийн менежмент, зах зээлийн эрсдэл, банкны тухай хууль, банкны нягтлан бодох бүртгэл, зээлийн эрсдэлийн шинжилгээ, худалдааны санхүүжилт, банкны менежментийн сэдвийн хүрээнд явагдсанаас ганцаарчилсан төрөлд НББ-Банкны 4-р дамжааны оюутан Б.Буянжаргал 3-р байранд, тус дамжааны оюутан Х.Ариунаа 4-р байранд тус тус шалгарч батламж, мөнгөн шагналаас гадна ХААН Банкинд ажиллах ажлын байрны урилга гардан авлаа.

Төгсөлт

Мандах Их Сургуулийн үүсгэн байгуулагдсны 27 жилийн ой, 24 дахь удаагийн төгсөлтийн хүндэтгэлийн үйл ажиллагаа Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Соёлын Төв Ордонд 2019 оны 05 сарын 08-ны өдөр ёслол төгөлдөр болж, тус сургуулийг Нягтлан бодох бүртгэл, Санхүү, Банк, Мэдээллийн технологийн мэргэжлээр төгссөн оюутнууд Бакалаврын зэргийн диплом, энгэрийн тэмдэгээ гардан авч ажил амьдралын гараагаа эхэллээ.



Редакцийн зөвлөл:

Ч.Төрбадрах / Сургалтын хөтөлбөр эрхэлсэн дэд захирал /
И-мэйл: turbadrakh@mandakh.mn

С.Булганаа / Гадаад хамтын ажиллагаа хариуцсан ажилтан /
И-мэйл: foreignrelations@mandakh.mn

Ц.Одгарав / НББТэнхимийн багш /
И-мэйл: odko@mandakh.mn